

**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ТОГТООЛ**

\_\_\_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_ өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

“Хувьцаат компанийн ногдол ашиг  
хуваарилах журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.14 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан журмыг баталсантай холбогдуулан өөрийн байгууллагын холбогдох дүрэм, журамд зохих өөрчлөлтийг оруулж, Санхүүгийн зохицуулах хороогоор батламжлуулахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д, журмын хэрэгжилтийг хангаж, чанд мөрдөн ажиллахыг нийт зохицуулалттай этгээд, хувьцаат компанийн удирдлагад тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын 1-д заасан журмыг баталсантай холбогдуулан Үнэт цаасны хорооны 2003 оны 65 дугаар, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 28 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

Санхүүгийн зохицуулах хорооны .....  
оны .... дугаар сарын .... -ны өдрийн  
.... дугаар тогтоолын хавсралт

## **ХУВЬЦААТ КОМПАНИЙН НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЖУРАМ**

### **НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Санхүүгийн зохицуулах хорооноос хувьцаат компаниас бэлэн мөнгө, эсхүл үнэт цаасны хэлбэрээр ногдол ашгийг хуваарилах, тайлагнах, түүнд хяналт тавихтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

### **ХОЁР.НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ**

2.1.Хувьцаат компани нь ногдол ашгийг татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилах бөгөөд Компанийн тухай хуульд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл, шаардлагыг хангасан байна.

2.2.Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашгийг жилийн эцсээр хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор, хагас жилээр хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд есөн сарын дотор тус тус хувьцаа эзэмшигчдэд хуваарилна.

2.3.Хувьцаат компани нь бэлэн мөнгөөр хуваарилах ногдол ашгийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага (цаашид “ҮЦТХТ” гэх)-аар дамжуулан хуваарилна.

2.4.Хувьцаат компани нь өөрийн арилжааны банкны нэр дээрх дансанд ногдол ашиг шилжүүлэх авах хүсэлт гаргасан давуу эрхийн болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг энэ журмын 2.2-т заасан хугацаанд шилжүүлнэ.

### **ГУРАВ.НОГДОЛ АШГИЙГ ҮНЭТ ЦААСНЫ ХЭЛБЭРЭЭР ХУВААРИЛАХ**

3.1.Хувьцаат компани нь ногдол ашгийг нэмж хувьцаа гарган эзэмшүүлэх замаар өөрийн компанийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилах бөгөөд Компанийн тухай хуульд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл, шаардлагыг хангасан байна.

3.2.Хувьцаат компани нь ногдол ашгийг энэ журмын 3.1-д заасны дагуу нэмж хувьцаа гаргах замаар хуваарилах тохиолдолд Хороонд бүртгүүлнэ.

3.3.Хувьцаат компани нь нэмж хувьцаа гаргах хүсэлтийг дараах баримт бичгийн хамт Хороонд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ:

3.3.1.компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр;

3.3.2.арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэсэн талаарх шийдвэр, дүгнэлт;

3.3.3.нэмж хувьцаа гаргах замаар ногдол ашиг хуваарилахтай холбоотой зохицуулалт тусгагдсан компанийн дүрмийн төсөл;

3.3.4.нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ, нэмж хувьцаа гаргахтай холбоотой дэлгэрэнгүй танилцуулга;

3.3.5.хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах талаар хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээлэл;

3.3.6.зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

3.4.Хороо энэ журмын 3.2-т заасан баримт бичгийн бүрдэл бүрэн хангагдсан өдрөөс хойш ажлын 20 өдөрт багтаан хянаж, бүртгэх эсэхийг шийдвэрлэх ба тус шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор арилжаа эрхлэх байгууллага, ҮЦТХТ-д өөрийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Хорооны даргын албан бичгээр мэдэгдэнэ.

3.5.Арилжаа эрхлэх байгууллага, ҮЦТХТ нь энэ журмын 3.4-д заасан Хорооны даргын албан бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор үнэт цаас гаргагчийн бүртгэлд өөрчлөлт оруулах ажиллагааг хэрэгжүүлнэ.

### **ДӨРӨВ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ**

4.1.ҮЦТХТ нь хувьцаат компанитай ногдол ашиг хуваарилах гэрээ байгуулсан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор тухайн компанийн хувьцаа эзэмшигч, үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд, арилжаа эрхлэх байгууллага болон Хороонд тус тус мэдэгдэнэ.

4.2.Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь ҮЦТХТ-өөс ногдол ашиг хуваарилахтай холбоотой мэдээлэл ирсэн даруйд ажлын таван өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.

4.3.Хувьцаат компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор энэ журмын хавсралтад заасан маягтын дагуу Хороонд цаасан, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

4.4.ҮЦТХТ нь хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилсан тухай мэдээллийг ногдол ашиг хуваарилснаас хойш ажлын таван өдрийн дотор үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

4.5.Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага нь энэ журмын 4.4-д заасан мэдээллийг нэгтгэн өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр олон нийтэд мэдээлнэ.

**ХУВЬЦААТ КОМПАНИЙН НОГДОЛ  
АШИГ ХУВААРИЛАЛТЫН ТАЙЛАН**

Огноо:	...../...../..... (0000,сс,өө)
Дугаар:	.....

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНД**

<b>1.</b>	<b>Компанийн мэдээлэл</b>	
1.1.	Компанийн нэр:	
1.2.	Регистрийн дугаар:	
1.3.	Эзэмшдэг тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн дугаар, огноо, олгосон эрх бүхий байгууллага, хугацаа:	
1.4.	Компанийн нийт хувьцааны тоо, ширхэг:	
1.5.	Компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо:	
<b>2.</b>	<b>Ногдол ашгийн мэдээлэл</b>	
2.1.	Ногдол ашгийн хэлбэр:	<input type="checkbox"/> Бэлэн мөнгө <input type="checkbox"/> Үнэт цаас
	Бэлэн мөнгөөр хуваарилсан бол нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ:	
	Нэмж хувьцаа гаргах замаар ногдол ашгийг хуваарилсан бол нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн тоо хэмжээ:	
2.2.	Нийт ногдол ашиг:	
2.3.	Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн компанийн эрх бүхий этгээдийн шийдвэрийн огноо, дугаар:	
2.4.	Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргасан өдөр:	
2.5.	Ногдол ашиг төлж эхэлсэн болон дууссан огноо:	
2.6.	Ногдол ашгийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар дамжуулан хуваарилсан гэрээний огноо, дугаар:	
2.7.	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар дамжуулан тараахаар байршуулсан огноо:	
2.8.	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар тараалгасан ногдол ашгийн	

	<i>мэдээлэл:</i>	
<i>2.9.</i>	<i>Олгогдоогүй ногдол ашгийг үлдэгдэл:</i>	